



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН  
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2026-2027 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага**

**Хууль зүйн үндэслэл**

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөл суурилсан төсвийн бодлогын баримт бичгийг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхээр тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

**Практик шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн Хамтарсан Засгийн газар байгуулагдаж, “Хурдтай Хөгжлийн Төлөөх Зориг” үнэт зүйлд нэгдэж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлж байна.

Энэ хүрээнд З намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод сууринсан "ХҮРДТАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ" Хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулагдаж, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон. Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурлаар батлуулаад байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны төсвийн тодотголоор гадаадын зээл тусlamжаар хэрэгжүүлэх дэд бүтцийн томоохон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлснээс гадна бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан томоохон хөгжлийн төслүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн санхүүжилтийг тусгасан.

Харин ирэх 2025 оны төсвийн төсөлд энэхүү томоохон хөгжлийн төслүүдийн барилга, угсралтын ажлыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудын санхүүжилтийг тусгаж байна. Ингэснээр эрчим хүчиний салбарт либералчлалыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эрчим хүчиний салбарын үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлыг нэмэгдүүлж, эдийн засгийн багтаамжийг тэлнэ. Салбаруудын үйлдвэрлэлд шинжлэх ухааны оолт, технологийн дэвшил, инновацыг дэмжих, тоног төхөөрөмжийн татвар, тарифыг хөнгөлөх бодлого хэрэгжүүлж, хөдөө аж ахуй, боловсруулах, уул уурхай гэх мэт салбаруудад зэрэг нөлөө үзүүлнэ. Мөн хөрш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр хийн гадаад эрэлтийг тэлснээр аж үйлдвэр, боловсруулах салбарыг дэмжинэ. Түүнчлэн, гадаад жуулчдын тоо, аялал жуулчлалын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд худалдаа, үйлчилгээний салбар болон бусад салбаруудын идэвхжилд эергээр нөлөөлнө.

Мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт орсон.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд болон үзүүлэлтийн хэмжээг өөрчлөх шаардлагатай байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

**Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.**

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар макро эдийн засгийн суурь үзүүлэлтуудийг зөв тооцож, улсын төсвийг үр нөлөөтэй оновчтой төлөвлөх, хуваарилах асуудал бодитой болох юм.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуулттай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

---00---